

ЭХ ДЭЛХИЙН ДҮРЭМ

ӨМНӨХ ҮГ

Хүн төрөлхтөн ирээдүйгээ сонгох тэр цаг хугацаа буюу Эх Дэлхийн түүхэн мөчид бид амьдарч байна. Дэлхий улам өөр хоорондоо хамааралтай, хэврэг болж байгаа үед аз туршсан, амлалтаар дүүрэн ирээдүй биднийг угтаж байна. Урагшлахын тулд бид соёл заншил, амьдралын хэв жаягын гайхамшигт олон төрөлт байдлын дунд бид нийтлэг зорилготой нэгэн гэр бүл, эх дэлхийн нэгэн төрөл зүйл гэдгээ ухамсарлах ёстой. Байгаль орчин, хүний нийтлэг эрх, эдийн засгийн шударга ёс болон энх тайвны соёлын хүндлэл дээр тулгуурласан тогтвортой дэлхийн нийгмийг бид хамтдаа байгуулах ёстой. Ингэхийн тулд Дэлхийн хүмүүс бид бие биенийхээ өмнө, хамтын сайхан амьдралынхаа болон ирээдүй хойч үеийнхээ төлөө хүлээх хариуцлагаа тунхаглаж чадах нь зайлшгүй нэгэн шаардлага билээ.

Эх дэлхий, бидний орон гэр

Хүн төрөлхтөн ихээр өөрчлөн хувьсаж буй орчлонгийн нэгээхэн хэсэг билээ. Бидний орон гэр болох Эх Дэлхий маань амьдралын онцгой нийгэмлэг бүхий амьд ертөнц юм. Байгалийн хүчин нь шаардлага өндөртэй, таагдашгүй адал явдалт оршихуйг бий болгодог хэдий ч Эх Дэлхий амьдралын өөрчлөлт хувьсалд шаардлагатай нөхцлийг бидэнд олгосон билээ. Амьдралын олон төрөл, уян хатан оршихуй болон хүн төрөлхтний сайн сайхан байдал нь экологийн бүх цогц системүүд бүхий эрүүл биосфера, төрөл бүрийн ургамал, ан амьтан, үр шимтэй хөрс, цэвэр ус агаарыг хадгалан хамгаалахаас ихээхэн хамаардаг. Барагдашгүй бус баялаг бүхий дэлхий дахины байгаль орчин бүх хүний санааг зовоосон нийтлэг асуудал болоод байгаа билээ. Эх дэлхийн оршихуй, олон төрөл зүйлс болон гоо үзэсгэлэнг нь хамгаална гэдэг ариун дагшин итгэл үнэмшил юм.

Дэлхий дахины нөхцөл байдал

Үйлдвэрлэл болон хэрэглээний хүчирхэг хэв шинж байгаль орчныг доройтуулан сүйтгэх, байгалийн баялагыг үгүйрүүлэн хоосруулах, төрөл зүйлийг устган алга болгох шалтгаан болж байна. Төрөл зүйлс цөөрч устгагдсаар байна. Хөгжлийн ашиг тусыг ижил тэгш хуваахгүй байгаа нь баян, ядуугийн хоорондох ялгааг улам ихэсгэсээр байна. Ядуурал, үл ойшоолт болон хэрцгий сөргөлдөөн газар авч гуниг зовлонг дагуулсаар байна. Өмнө нь хэзээ ч байгаагүйгээр өссөн хүн амын өсөлт экологийн болон нийгмийн системүүдэд хэтэрхий их ачаалал, бэрхшээл авчирчээ. Дэлхий дахины аюулгүй байдлын үндэс суурьд аюул нүүрлэсэн байна. Эдгээр хандлага нь аюултай – гэхдээ, яахаа алдсан гэсэн үг биш.

Өмнө тулгарч буй сорилтууд

Сонголт бол биднийх: эх дэлхийгээ хайрлах дэлхий дахины нэгэн түншлэл байгуулах уу эсхүл өөрсдийн болон амьдралын төрөл зүйлийн сүйрлийн эрсдлийг хүлээх үү. Бидний үнэт зүйлс, институци болон амьдралын хэв жаягт томоохон өөрчлөлтүүд шаардлагатай болжээ. Үндсэн хэрэгцээгээ хангасны дараа хүний хөгжил гэдэг нь илүүтэй байх бус илүү байхыг хэлнэ гэдгийг бид ухамсарлах ёстой. Бүгдэд хүртээх, байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллөө бууруулах мэдлэг, технологи бидэнд бий. Дэлхий дахины иргэний нийгмийн үүсэл нь ардчилсан бөгөөд хүмүүнлэг ертөнцийг байгуулах шинэ боломжуудийг бий болгож байна. Бидний байгаль орчны, эдийн засгийн, улс төрийн, нийгмийн болон сэтгэлзүйн сорилтууд өөр хоорондоо холбогдсон бөгөөд бид хамтдаа төгс шийдлүүдийг цогцлуулж чадна.

Нийтлэг хариуцлага

Эдгээр хүсэл эрмэлзлэлийг биелүүлэхийн тулд бид өөрсдийгөө Дэлхийн хамтын нийгэмлэг болон орон нутгийн хамтын нийгэмлэгтэйгээ холбон тодорхойлж нийтлэг хариуцлагын мэдрэмжтэйгээр амьдрах шийдвэрийг гаргах ёстой. Бид өөр өөр улс орны, үндэсний ба дэлхий дахины асуудал харилцан уялддаг нэгэн дэлхийн иргэд билээ. Хүн бүр хүн

төрөлхтөний гэр бүл болон бусад амьд ертөнцийн өнөөгийн болон ирээдүйн сайн сайхны төлөөх хариуцлагыг хуваалцдаг. Үл тайлагдах нууцлаг оршихуйн ертөнцөд амьдарч, амьдрал хайрласан бэлэгт талархаж, шүтэж явах үед хүн төрөлхтөний амьд ертөнцтэй бий болгосон эв нэгдлийн үзэл санаа төлөвшиж бэхждэг.

Үүсэн бий болж буй дэлхийн хамтын нийгэмлэгт ёс зүйн үндэс суурь нь болох үндсэн үнэт зүйлсийн хамтын төсөөлөл бидэнд яаралтай хэрэгтэй байна. Тиймээс, дараахь өөр хоорондоо хамааралтай зарчмуудыг амьдралын тогтвортой хэв жаяг хэмээн үзэж бүх хувь хүн, байгуулагууд, бизнесүүд, засгийн газрууд болон олон үндэстэн дамнасан институциудийн удирдамж болгодог, үнэлэгддэг нийтлэг стандарт болохыг итгэл найдвар өвөрлөн баталж байна.

ЗАРЧМУУД

I. АМЬДРАЛЫН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ХҮНДЛЭХ, ХАЙРЛАХ

1. Эх дэлхий болон амьдралын бүхий л төрөл зүйлийг дээдлэх.

- а. Хүнд ямар үнэ цэнэтэй вэ гэдгээсээ үл хамааран бүх амьд биетүүд өөр хоорондоо хамааралтай, амьдралын хэлбэр бүр үнэт зүйлстэй гэдгийг ухамсарлаж хүлээн зөвшөөрөх.
- б. Бүх хүний төрөлхийн сүр хүч болон хүн төрөлхтөний оюун ухаан, ур авъяас, ёс зүй, сэтгэл санааны хүчид итгэдэг итгэлээ батлах.

2. Амьдралын төрөл зүйлийг ойлгож, өрөвдөж, хайрлаж хамгаалах.

- а. Байгалийн баялагыг эзэмших, зохицуулах, ашиглах эрхийн хамт байгаль орчныг сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хүмүүсийг эрхийг хамгаалах үүрэг хариуцлага ирдэг гэдгийг хүлээн зөвшөөрөх.
- б. Нэмэгдсэн эрх чөлөө, мэдлэг болон эрх мэдэлтэй хамт нийтлэг сайн сайхан зүйлсийг дэмжих хариуцлага ирдэг гэдгийг батлах.

3. Шударга, оролцооны, тогтвортой бөгөөд энх тайванч ардчилсан нийгмүүдийг байгуулах.

- а. Бүх төвшний хамтын нийгэмлэгүүд хүний эрх ба гол эрх чөлөөг хангах явдлыг баталгаажуулах, хүн бүрт өөрийн ур чадавхиа бүрэн ашиглах боломжийг олгох.
- б. Бүгдэд аюулгүй, утга учиртай мөн экологийн хариуцлагатай амьжиргааг бүрдүүлэх бололцоог бий болгож нийгмийн болон эдийн засгийн шударга ёсыг хөхүүлэн дэмжих.

4. Эх Дэлхийн бэлэг, үзэсгэлэнг өнөөгийн болон ирээдүй хойч үеийнхэнд өвлөн үлдээх.

- а. Үе бүрийн үйлдлийн эрх чөлөө нь хойч үеийнхний эрэлт хэрэгцээгээр тодорхойлогддог гэдгийг хүлээн зөвшөөрөх.
- б. Эх Дэлхийн хүний болон экологийн хамтын нийгэмлэгийн урт хугацааны цэцэглэн хөгжлийг дэмжих үнэт зүйлс, уламжлал болон байгууллагуудыг ирээдүй хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээх.

Эдгээр өргөн хүрээтэй дөрвөн үүрэг амлалтыг биелүүлэхийн тулд дараахь зүйлсийг хийх шаардлагатай. Үүнд:

II. ЭКОЛОГИЙН ТӨГС БАЙДАЛ

5. Амьдралыг тогтворжуулж байдаг биологийн төрөл зүйл болон байгалийн процессуудад онцгойлон анхаарч Эх Дэлхийн экологийн төгс байдлыг хамгаалах, нөхөн сэргээх.

- а. Байгаль орчны хамгаалалт болон нөхөн сэргээлтийг хөгжлийн бүх санаачлагуудын бүрдэл хэсэг болгон тогтвортой хөгжлийн төлөвлөгөөнүүд болон хууль тогтоомжуудыг батлах.
- б. Эх Дэлхийн амьдралыг тэтгэгч системүүдийг хамгаалах, биологийн төрөл зүйлийг хадгалах, байгалийн өв хөрөнгөө хамгаалахын тулд онгон газар нутаг, далай тэнгисийн бүс зэрэг байгалийн болон биосферийн нөөцийг бий болгох, хайрлан хамгаалах.
- в. Ховордсон төрөл зүйлс болон экосистемүүдийг нөхөн сэргээх ажиллагааг хөхүүлэн дэмжих.

- г. Уугуул төрөл зүйл болон байгаль орчинд халтай уугуул бус эсвэл генетикийн хувьд өөрчилсөн организмуудыг хянах, устгах, ийм төрлийн хортой организмуудыг нэвтрэх, бий болгохоос урьдчилан сэргийлэх.
- д. Нөхөн үржихүйн хэв хэмжээнээс үл хэтрүүлэх байдлаар болон экосистемүүдийн эрүүл мэндийг хамгаалах байдлаар ус, хөрс, ойн бүтээгдэхүүнүүд, далай тэнгисийн амьдрал зэрэг сэргээгдэх баялагыг ашиглалтыг удирдан зохицуулах.
- е. Нөөц шавхалтыг бууруулах, байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар ашигт малтмал, газрын тос зэрэг үл сэргээгдэх баялагын ашиглалт, олборлолтыг удирдан зохицуулах.

6. Байгаль орчныг хамгаалах хамгийн шилдэг арга болгон хохирол, хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг хязгаарлагдмал байгаа үед болгоомжилсон арга барилыг хэрэглэх.

- а. Шинжлэх ухааны мэдлэг бүрэн төгс болоогүй эсвэл эцэслэн дүгнээгдээгүй байгаа үед ч ноцтой эсвэл эргэн хэзээ ч засч үл болох байгаль орчны хохирол гарах боломжоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.
- б. Санал болгож байгаа үйл ажиллагаа нь ноцтой хохирол учруулахгүй хэмжээн үзэж байгаа хүмүүст нотолгооны хязгаарлалт тавьж байгаль орчинд хохирол учруулсан этгээдүүдэд хариуцлага тооцох.
- в. Шийдвэр гаргалт нь хүний үйл ажиллагаануудын хуримтлагдах, урт хугацааны, шууд бус, алслагдсан болон дэлхий дахинд учруулж болохуйц үр дагаваруудад харгалзан үзсэн байх явдлыг баталгаажуулах.
- г. Байгаль орчны ямар ч хэсэг бохирдохоос урьдчилан сэргийлэх, радио цацрагт бодис, химийн хортой бодис эсвэл бусад хотой бодисууд хуримтлагдахыг үл зөвшөөрөх.
- д. Байгаль орчинд хохирол учруулах цэрэг, армийн үйл ажиллагаануудаас зайлсхийх.

7. Эх дэлхийн байгалийн нөхөн сэргээх чадавхи, хүний эрх болон хамтын нийгэмлэгийн сайн сайхныг хадгалан хамгаалах үйлдвэрлэлийн, хэрэглээний болон нөхөн үржихүйн хэв шинжийг сонгох.

- а. Үйлдвэрлэлийн болон хэрэглээний системүүдэд ашиглагдсан материалуудыг багасгах, дахин ашиглах, гарсан хог хаягдал экологийн системүүдээр шингээгдэж, цэвэршигдэж байх явдлыг баталгаажуулах.
- б. Эрчим хүч ашиглаж байхдаа хэмнэлттэй хандах, нар, салхи зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх сурвалжууд дээр илүүтэйгээр түшиглэх.
- в. Байгаль орчинд халгүй технологиудыг хөгжүүлэх, ашиглах, ижил тэгш байдлаар шилжүүлэх явдлыг хөхүүлэн дэмжих.
- г. Бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний байгаль орчны болон нийгмийн зардлыг борлуулалтын үнэ өртөгт дотоодын болгох, нийгмийн болон байгаль орчны хамгийн өндөр стандартыг хангасан бүтээгдэхүүнийг олж тодорхойлох чадавхийг хэрэглэгчдэд олгох.
- д. Нөхөн үржихүйн эрүүл мэнд болон хариуцлагатай нөхөн үржихүйг тэтгээдэг эрүүл мэндийн нийтлэг үйлчилгээг баталгаажуулах.
- е. Дуусашгүй нөөцтэй бус энэ дэлхийд амьдралын чанар болон материаллаг эд зүйлсийн хангалттай байдлыг онцолдог амьдралын хэв жаягыг нэвтрүүлэх.

8. Экологийн тогтвортой байдлын судлагааг гүнзгийрүүлэх, олсон мэдлэгээ нээлттэй хуваалцах, өргөнөөр хэрэглэх явдлыг идэвхжүүлэх.

- а. Хөгжиж буй орнуудын эрэлт хэрэгцээг онцгойлон анхаарч тогтвортой байдал дээрх олон улсын шинжлэх ухааны болон техникийн хамтын ажиллагааг дэмжих.
- б. Байгаль орчны хамгаалал болон хүний сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулдаг бүх соёл заншлын уламжлалт мэдлэг, сэтгэл зүй, цэцэн ухааныг хүлээн зөвшөөрөх, хадгалан өвлүүлэх.
- в. Генетикийн мэдээлэл зэрэг хүний эрүүл мэндэд амин чухал мэдээллүүдийг нийтэд хүртээлтэй байлгах явдлыг баталгаажуулах.

III. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ШУДАРГА ЁС

9. Ядуурлыг ёс зүйн, нийгмийн болон байгаль орчны зайлшгүй шаардлага хэмээн үзэж үгүй болгох.

- а. Үндэсний болон олон улсын нөөц эх сурвалжуудыг хуваарилах замаар ундны ус, цэвэр агаар, хүнсний аюулгүй байдал, бохирдоогүй хөрс, орон байр болон аюулгүй эрүүл ахуйн орчноор хангагдах эрхийг баталгаажуулах.

- б. Хүн бүрт тогтвортой амьжиргааг баталгаажуулахад шаардагдах боловсрол болон эх сурвалжаар хангагдах эрх мэдлийг олгох, өөрсдийгөө дэмжих чадваргүй хүмүүсийг нийгмийн хангамж болон аюулгүй байдлын сүлжээгээр хангах.
- в. Үл тоогдсныг хүлээн зөвшөөрөх, эмзэг бүлгийнхнийг хамгаалах, зовж байгаа хүмүүст үйлчлэх замаар хүсч мөрөөдснөө биелүүлэх тэдний чадавхийг хөгжүүлэх боломжийг олгох.

10. Эдийн засгийн үйл ажиллагаа болон байгууллагууд бүх шатанд хүний хөгжлийг эрх тэгш, тогтвортой хэлбэрээр хөхүүлэн дэмждэг байх явдлыг баталгаажуулах.

- а. Баялагыг ижил тэгшээр улс орон дотроо болон улс орнуудын дунд хуваарилах явдлыг хөхүүлэн дэмжих.
- б. Хөгжиж буй орнуудын оюун ухаан, санхүү, техникийн болон нийгмийн баялагыг бэхжүүлэх, тэднийг олон улсын дарамттай өр төлбөрөөс чөлөөлөх.
- в. Бүх худалдаа арилжаа баялагын тогтвортой ашиглалт, байгаль орчны хамгаалал болон хөдөлмөрийн дэвшилтэт стандартуудыг дэмжиж байх явдлыг баталгаажуулах.
- г. Улс орон дамнасан корпорациуд болон олон улсын санхүүгийн байгууллагуудыг олон нийтийн салбарт ил тодоор ажиллахыг шаардах, үйл ажиллагааных нь үр дагавараас нь хамааран тэдэнд хариуцлага тооцох.

11. Жендерийн эрх тэгш байдал болон эрх тэгш байдал нь тогтвортой хөгжлийн гол шаардлага гэдгийг батлах; боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ болон эдийн засгийн боломжийг нийтлэгээр хүртэх явдлыг баталгаажуулах.

- а. Эмэгтэйчүүд, охидын хүний эрхийг баталгаажуулах, тэдний эсрэг бүх төрлийн хүчирхийллийг эцэслэх.
- б. Бүрэн бөгөөд ижил тэгш түнш, шийдвэр гаргагч, лидер, ашиг тус хүртэгч гэдэг утгаар нь эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцоог эдийн засгийн, улс төрийн, иргэний, нийгмийн болон соёл урлагын бүхий л салбарт хөхүүлэн дэмжих.
- в. Гэр бүлийг бэхжүүлэх, өрхийн гишүүн бүрийг хайраар дүүрэн, аюулгүй байдлаар хангагдсан байх явдлыг баталгаажуулах.

12. Уугуул нутгийн хүмүүс болон цөөнхнийхөнд онцгойлон анхаарч хүний сүр хүч, бие бялдрын эрүүл мэнд, сэтгэл санааны сайн сайхан байдлыг байгалийн болон нийгмийн орчинд дэмжих бүх хүмүүсийн эрхийг ялгаварлан гадуурхалгүйгээр хүндлэн дээдлэх.

- а. Үндэстэн, арьсны өнгө, хүйс, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг, хэл, үндэстэн ястан, нийгмийн гарал үүсэл зэргээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрүүдийг устгах.
- б. Уугуул хүмүүсийн зан заншил, мэдлэг, газар нутаг, баялаг, тогтвортой амьжиргааны холбогдох практикийг хадгалах эрхийг баталгаажуулах.
- в. Хамтын нийгэмлэгийнхээ залуу хүмүүсийг хүндэтгэх, дэмжих, тогтвортой нийгмүүдийг бий болгоход шаардагдах үндсэн үүрэг ролио биелүүлэх боломжийг тэдэнд олгох.
- г. Соёлын болон зан үйлийн өв болох гайхамшигт газруудыг хамгаалах, нөхөн сэргээх.

IV. АРДЧИЛАЛ, ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ БА ЭНХ ТАЙВАН

13. Ардчилсан байгууллагуудыг бүх түвшинд бэхжүүлэх; засаглал, шийдвэр гаргалтанд оролцох бүрэн төгс оролцоо болон шудрага ёсны хүртээмжид ил тод байдал болон хариуцлагын тогтолцоог бий болгох.

- а. Байгаль орчинтой холбоотой асуудлууд болон хүмүүст нөлөөлж болохуйц эсвэл хүмүүсийн сонирхож буй хөгжлийн бүх төлөвлөгөөнүүд болон арга хэмжээнүүдийн талаарх тодорхой бөгөөд цаг хугацаагаа олсон мэдээллийг хүн бүр авч байх эрхийг дээдлэх.
- б. Орон нутгийн, бүс нутгийн болон дэлхийн дахины иргэний нийгмийг дэмжих, сонирхож буй бүх хувь хүмүүс болон байгууллагуудын утга учиртай оролцоог идэвхжүүлэх.
- в. Санаа бодлоо илэрхийлэх, үг хэлэх, тайван замаар цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх, шүүмжлэх эрхүүдийг хамгаалах.
- г. Байгаль орчинд учруулсан хохирлыг засч залруулах болон ийм хор хохирлын аюултай холбогдолтой асуудлаар захиргааны болон бие даасан шүүн таслах байгууллагад хандах оновчтой бөгөөд үр бүтээлтэй системийг бий болгох.
- д. Олон нийтийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагуудад авилгалыг устгах.

- е. Орон нутгийн хамтын нийгэмлэгүүдийг бэхжүүлэх, байгаль орчноо өөрсдөө хайрлан хамгаалах боломжоор хангах, хамгийн оновчтойгоор үйл ажиллагаагаа явуулж болох төр засгийн түвшинг тодорхойлж байгаль орчны үүрэг хариуцлагыг ноогдуулах.

14. Амьдралын тогтвортой хэв жаягт шаардлагатай мэдлэг, үнэт зүйлс болон ур чадварыг албан ёсны боловсрол болон амьдралын туршид суралцах процесст нэгтгэх.

- а. Бүгдийг, нэн ялангуяа хүүхэд залуусыг, боловсрол олох боломжоор хангаж тогтвортой хөгжилд идэвхтэй хувь нэмрээ оруулах эрх мэдлийг тэдэнд олгох.
- б. Тогтвортой байдлын боловсролд соёл урлаг, хүмүүнлэгийн ёс зүй, шинжлэх ухааны хувь нэмрийг идэвхжүүлэх.
- в. Экологийн болон нийгмийн сорилтуудын талаарх ойлголтуудыг бий болгоход гүйцэтгэх олон нийтийн хэвлэл мэдээллийн үүрэг рөлийг өргөжүүлэх.
- г. Тогтвортой амьдралд дахь сэтгэл санааны болон зан үйлийн боловсролын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх.

15. Бүх амьд биетүүдтэй хүндэтгэлтэйгээр харьцах.

- а. Хүний нийгэмд амьдарч байгаа амьтдад зэрлэг догшиноор хандах хандлагаас урьдчилан сэргийлэх, тэднийг зовж шаналахаас хамгаалах.
- б. Хэтэрхий, удааширсан эсвэл зайлсхийж болох шаналлыг бий болгох агнах, хавх тавих, загаслах аргуудаас зэрлэг ан амьтдыг хамгаалах.
- в. Зорилтот бус төрөл зүйлийг барих эсвэл устгахаас зайлсхийх эсвэл аль болохоор бүрмөсөн татгалзах.

16. Тэвчээр, үл хүчирхийлэл болон энх тайвны соёлыг хөхүүлэн дэмжих.

- а. Улс орон доторх болон улс орнуудын дундах бүх хүмүүсийн харилцан ойлголцол, эв нэгдэл, хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих.
- б. Хэрцгий зөрчилдөөн гарахаас урьдчилан сэргийлэх цогц стратегиудыг хэрэгжүүлэх, байгаль орчны болон бусад маргааны шийдвэрлэх, зохицуулах хамтын хэлэлцээрийг ашиглах.
- в. Үндэсний аюулгүй байдлын системүүдийг өдөөсөн бус статусын түвшинд хүртэл цэрэгжүүлэлтийг багасгах, экологийн нөхөн сэргээлт зэрэг энх тайвны зорилгоор цэрэг, батлан хамгаалах хүчинг ашиглах.
- г. Цөмийн, биологийн, химийн зэвсэг болон бусад нийтээр устгах зэвсгийг устгах.
- д. Агаар мандал болон сансар огторгуйн ашиглалт нь байгаль орчны хамгаалалт болон энх тайвныг дэмжиж байх явдлыг баталгаажуулах.
- е. Энх тайван гэдэг бол өөртэйгөө, бусад хүмүүстэй, бусад соёл заншилтай, бусад амьдралтай болон бид бүгд нэгэн хэсэг нь болдог Эх Дэлхийтэй тогтоосон зөв харилцаануудын бүрдэл цөм гэдгийг хүлээн зөвшөөрөх.

УРАГШЛАХ ЗАМ

Түүхэнд хэзээ ч өмнө нь байгаагүйгээр нийтлэг хувь заяа маань биднийг шинэ эхлэл эрэлхийлэхэд дуудаж байна. Ийм шинэчлэлийг Эх Дэлхийн эдгээр зарчмууд амлаж байгаа юм. Энэ амлалтыг биелүүлэхийн тулд бид Эх Дэлхийн үнэт зүйлс, зорилтуудыг сонгох, хөхүүлэн дэмжихэд өөрсдийгөө зориулах ёстой.

Энэ нь оюун санаа болон сэтгэл зүрхэндээ өөрчлөлт хийхийг шаардана. Энэ нь дэлхий дахины харилцан хамаарал болон нийтлэг хариуцлагыг шаардана. Бид тогтвортой амьдралын хэв жаягын зөн, таамаглалыг орон нутгийн, үндэсний, дэлхий дахины хэмээнд тархи толгойндоо боловсруулах, хэрэглэх ёстой. Бидний соёлын олон талт байдал нь үнэт өв хөрөнгө бөгөөд өөр өөр соёл заншил, зөн мөрөөдлийг биелүүлэх өөрсдийн арга замуудаа олгох болно. Эх Дэлхийн Дүрмийг бий болгосон дэлхий дахиныг хамарсан ярилцлага, хэлэлцүүлгийг улам өргөжүүлэх, гүнзгийрүүлэх шаардлагатай бөгөөд ингэхийн тулд үнэн болон мэргэн ухааныг олох зорилготой хамтарсан судлагаанаас бид олон зүйлийг суралцах ёстой.

Амьдрал ихэвчлэн чухал үнэт зүйлсийн хооронд хурцадмал байдлыг үүсгэдэг. Энэ нь хэцүү сонголт хийнэ гэсэн үг. Гэхдээ, олон талт байдлын эв нэгдэл, нийтлэг сайн сайхны төлөө эрх чөлөөгөө эдлэх, богино хугацааны зорилтууд болон урт хугацааны зорилгуудыг уялдуулан нийцүүлэх арга замыг бид олох ёстой. Хувь хүн, гэр бүл, байгууллага, хамтын нийгэмлэг бүр чухал үүрэг рольтой. Соёл урлагууд, шинжлэх ухаанууд, хэвлэл мэдээллүүд, бизнесүүд, төрийн бус байгууллагууд болон засгийн газруудыг уран сэтгэмжит манлайлал бий болгохыг уриалж байна. Оновчтой засаглалд засгийн газар, иргэний нийгэм болон бизнесийн түншлэл нэн шаардлагатай.

Дэлхий дахины тогтвортой хамтын нийгэмлэг байгуулахын тулд дэлхийн улс орнууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын өмнө хүлээсэн үүрэг амлалтаа шинэчлэх, одоогоор мөрдөгдөж байгаа олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн хүрээнд үүрэг хариуцлагаа биелүүлэх, байгаль орчин ба хөгжлийн асуудалд чиглэсэн олон улсын хууль эрхзүйн хэрэгслээр дамжуулан Эх Дэлхийн Дүрмийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой.

Бидний амьдарч буй энэ цаг үе амьдралыг дээдлэх шинэ хүндлэлийг сэрээсэн, тогтвортой байдлыг бий болгохыг тууштай шийдвэрлэсэн, шударга ёс болон энх тайвны төлөөх тэмцлийг хурдасгасан, амьдралын сайн сайхныг магтан дуулсан цаг үе байсан гэдгээр нь дурсагдах цаг үе байх болтугай.